

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/129/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**
Утас: **7037-3089, 9902-3869**
Цахим хаяг: **Munkhbayarsh@audit.gov.mn**
Аудитор: Ч.Гантулга
Утас: **9937-2297**
Цахим хаяг: **GantulgaCh@audit.gov.mn**



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨСВИЙН АУДИТЫН АЖААР**

40150 Дархан-Уул аймаг
Дархан сум, 14-р байр
Утас 7027-4225, 4400-8176, 7027-4228
E-mail: darhanuaa@audit.gov.mn

2022.02.25 № 005

Төрийн аудитын санал дүгнэлт

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ШҮҮХИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА
ХОШУУЧ Б. ТҮВШИНТӨР ТАНАА



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зөврийн дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэх болох бөгөөд дангвараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш МӨНХБАЯР

009020133



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/мян.төг/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,372.6	3,805.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	702,076.4	685,368.4
	Нийт хөрөнгийн дүн	704,449.0	689,173.7
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	704,449.0	689,173.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	704,449.0	689,173.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	218,296.3	235,675.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	221,448.5	250,750.7
	Үйл ажиллагааны үр дүн	(3,152.2)	(15,075.3)
	Үйл ажиллагааны бус үр дүн	400.0	200.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(3,552.4)	(15,275.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	704,449.0	689,173.7
	Тайлант оны үр дүн	(3,552.2)	(15,275.3)
	Эцсийн үлдэгдэл	704,449.0	689,173.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	202,259.7	231,675.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	200,818.4	230,816.3
	Үйл ажиллагааны ЦМГ	1,441.3	859.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	1,441.3	859.1
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	931.3	2,372.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,372.6	3,231.7
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	223,453.7	221,306.4
	Урсгал зардал	223,453.7	221,306.4
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	223,453.7	221,306.4
	Улсын төсвөөс санхүүжих	217,453.7	215,306.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь Шинжлэх ухааны тодорхой салбарын шинжилгээ судалгааны онол арга, барилд түшиглэн өндөр түвшинд зохион байгуулж ул мөр, эд мөрийн баримт цуглуулах хэргийн холбогдолтой ул мөр, эд мөрийн баримт материалуудад өндөр технологи бүхий лабораторийн техник хэрэгсэл ашиглан шүүх прокурор, хэрэг бүртгэх мөрдөн байцаах байгууллагаас ирүүлсэн тогтоол захирамжийн дагуу шинжилгээ хийж шинжлэх ухааны үндэслэлтэй үнэн зөв дүгнэлт магадлагаа гарган өгөх нарийн мэрэгжлийн чадварлаг зарчимч шудрага үнэнч, мэргэшсэн албан хаагчдыг үр дүнтэй тогтвортой ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэх зорилготойгоор хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Дархан-Уул аймгийн Шүүхийн шинжилгээний алба нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан-Уул аймгийн Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны мэдээлэлд 149 мэдээлэл оруулахаас 5 сард 11 мэдээ хугацаа хоцроосон байна. /Тус байгууллагын нягтлан бодогч 5 дугаар сард буяны ажил гарч, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн удирдлагаас албан ёсны чөлөө авсан байна/

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Шүүхийн шинжилгээний албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд алдаа зөрчил илрээгүй болно.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		Аудит ад хамр аглаж	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр	

